

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2015 оны 03 сарын 07 өдөр

№ 11

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг 2015 оны 3 дугаар сарын 4-ний өдөр “Авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагаа, хяналт шалгалтыг бэхжүүлэх” төслийг төлөөлж Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороолол, Сөүлийн гудамж 41-т байрлах Авлигатай тэмцэх газар (цаашид “Үйлчлүүлэгч” гэх) [утас: 70112467, факс: 70112463] болон Шинэ Зеланд Улс, Окланд хот, Лемингтон роуд 19–д байрлах Крис Алберино [паспортын дугаар: LN503882] (цаашид “Зөвлөх” гэх, хамтад нь “талууд” гэх) нар байгуулав.

НЭГ ТАЛААС, үйлчлүүлэгч нь зөвлөхөөс дор дурьдсан үйлчилгээ үзүүлэхийг хүсч,

НӨГӨӨ ТАЛААС, зөвлөх нь эдгээр үйлчилгээг үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлж,

ТАЛУУД дараах байдлаар харилцан тохиролцов.

1. Үйлчилгээ
 - (I) Зөвлөх нь Хавсралт А буюу гэрээний салшгүй хэсэг болох “Ажлын удирдамж”-д тодорхойлогдсон ажил үйлчилгээг гүйцэтгэнэ.
 - (II) Зөвлөх нь Хавсралт В буюу “Ажлын хуваарь”-т заасан хугацаанд зөвлөх үйлчилгээг үзүүлж, тайлагнана.
2. Гэрээний хугацаа
 - Зөвлөхийн ажиллах хугацаанд нэг долоо хоногийн бэлтгэл хангах хугацаа болон хоёр удаа Монгол Улсад ирж ажиллах хугацаа орсон болно. Эхний удаагийн Монгол Улсад ирж ажиллах хугацаа нь 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс 2015 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн хооронд үргэлжлэх бөгөөд зөвлөхийн хоёр дахь удаа ирж ажиллах хугацааг талууд цахим шуудангаар бичиж тохиролцоно. Зөвлөхийн замдаа зарцуулах хугацааг зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх үндсэн хугацаанд оруулж тооцно.
3. Төлбөр
 - А. Гэрээний дүнгийн хязгаар
Хавсралт А-д заасан ажлыг хийж гүйцэтгэсэний хариуд Үйлчлүүлэгч нь Зөвлөхөд 28'000 (хорин найман мянган) ам.долларын үйлчилгээний хөлсийг төлнө. Энэ дүнд Зөвлөхийн амь даатгал, зочид буудал, хоол болон бусад жижиг зардлыг оруулсан болно. Зөвлөхийн төлөх хувь хүний орлогын албан татварыг Үйлчлүүлэгч нь төлбөрийн баримтыг үндэслэн нөхөн олгох буюу төлнө. Зөвлөхийг онгоцны буудлаас тосож авах, үдэн гаргах болон байрласан зочид буудлаас Үйлчлүүлэгчийн байрлах газар хүртэлх унааны зардал, түүнчлэн орчуулга, компьютер, бичиг цаасны зардлыг Үйлчлүүлэгч хариуцна.

Б. Төлбөрийн хуваарь

Төлбөрийн хуваарийг доорх байдлаар тогтоов.

Гэрээний нийт дүнгийн 25 хувийг (7000 ам.доллар) Зөвлөхийг Монгол Улсад хүрэлцэн ирэхээс өмнө төлнө.

Гэрээний нийт дүнгийн 50 хувийг (14000 ам.доллар) Ажлын удирдамжийн 1 болон 2-т заасан шаадлагын дагуу тайланг Үйлчлүүлэгчид хүлээлгэн өгсөний дараа Зөвлөхөд төлнө.

Гэрээний нийт дүнгийн үлдсэн 25 хувийг (7000 ам.доллар) Зөвлөх хоёр дахь удаагаа Монгол Улсад хүрэлцэн ирж, ажиллах үеэр төлнө.

Гэрээний нийт үнийн дүн: 28'000 (хорин найман мянган) ам.доллар.

С. Төлбөрийн нөхцөл

Төлбөрийг ам.доллараар энэхүү гэрээний 4 дүгээр зүйлд томилогдсон зохицуулагчид зөвлөхийн үйлчилгээний нэхэмжлэх цахим шуудангаар хүргэгдсэнээс хойш календарийн 10 хоногийн дотор хийнэ.

Бүх төлбөрийг АНУ-ын Вашингтон хотод байрлах “Банк-Фонд Стаф Кредит Юнион” (АВА-Рутинг дугаар 2540-7417-0) банкин дахь Крис Албериногийн нэр дээрх 10074897 дугаар дансанд шилжүүлнэ.

4. Удирдлага

А. Зохицуулагч

Үйлчлүүлэгч нь Баатар овогтой Өлзийг (АТГ-ын ХШДШХ-ийн ахлах ажилтан, ахлах комиссар) зөвлөх үйлчилгээг хариуцсан зохицуулагчаар томилсон бөгөөд зохицуулагч нь энэхүү гэрээтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй буюу тайланг хүлээн зөвшөөрч, ажлын гүйцэтгэлд үнэлэлт өгөн дүгнэлт гаргаж баталгаажуулж, төлбөрийн баримт, нэхэмжлэхийг хүлээн авна.

Б. Тайлан

Зөвлөх нь Хавсралт Б-ийн “Ажил хүлээж авах хуваарь” хэсэгт заасан тайланг хүргүүлсэнээр 3 дугаар зүйлд заасан зөвлөхийн үйлчилгээний төлбөр хийгдэх үндсэн нөхцөл биелэгдэнэ.

5. Гүйцэтгэлийн стандарт

Зөвлөх нь мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар үйлчилгээг үзүүлнэ.

6. Хяналт шалгалт ба аудит

Холбогдох үйлчилгээг үзүүлэх тухай санал бэлдэж ирүүлэх болон гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой данс тооцоо, бүртгэл, бусад баримт бичгүүдийг Дэлхийн Банк эсвэл түүний томилсон этгээд буюу аудиторуд шалгах, аудит хийхийг Зөвлөх өөрөө зөвшөөрнө. Энэ үүргийг биелүүлэхгүй байх нь гэрээ цуцлах болон Дэлхийн Банкны хүчин төгөлдөр үйлчилж буй Шийтгэлийн журамд

нийцүүлэн хариуцлага тооцож болохуйц (ямар нэг хязгаарлалтгүйгээр эрх бүхий бус гэж тооцохыг оруулан) хориглосон үйлдэл гэж үзэж болно.

7. Нууцлал

Зөвлөх нь гэрээний хугацаанд болон гэрээ дууссанаас хойшхи 2 жилийн хугацаанд уг үйлчилгээ, тус гэрээ, Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотой аливаа өмчлөлийн буюу нууц мэдээллийг Үйлчлүүлэгчийн бичгээр хийсэн зөвшөөрөлгүйгээр задлахгүй.

8. Материалын өмчлөх эрх

Үйлчлүүлэгчид зориулан энэхүү гэрээний дагуу зөвлөхийн хийсэн аливаа ажлууд, реклам, судалгааны тайлан, график, программ хангамж гэх мэт бүхий л материалууд нь Үйлчлүүлэгчид хамаарах бөгөөд үйлчлүүлэгчийн өмч байна. Зөвлөх нь эдгээр материалууд болон программ хангамжийг хуулбарлан авч үлдэж болно. Зөвлөх нь үйлчлүүлэгчид бүх материалуудыг боловсруулан бэлтгэж өгнө.

9. Даатгал

Аливаа тохиромжтой даатгалд хамрагдах эсэхийг зөвлөх хариуцна.

10. Шилжүүлэлт

Зөвлөх нь Үйлчлүүлэгчийн бичгээр хийсэн зөвшөөрөлгүйгээр энэхүү болон гэрээний аливаа хэсгийг бусдад дамжуулан гэрээлэхийг хориглоно.

11. Гэрээг зохицуулах ба гэрээний хэл

Энэхүү гэрээ нь Монгол Улсын хуулиар зохицуулагдах ба гэрээг монгол, англи хэл дээр 2 хувь үйлдэнэ. Уг гэрээний монгол, англи хэл дээрх хувиуд адил тэнцүү хүчинтэй байна.

12. Маргаан шийдвэрлэх

Энэхүү гэрээтэй холбогдон үүссэн маргааныг талууд харилцан тохиролцож эс чадваас Үйлчлүүлэгчийн улсын хууль тогтоомжийн дагуу шүүхийн аргаар буюу арбитраар шийдвэрлэнэ.

13. Гэрээ цуцлах

Үйлчлүүлэгч энэ заалтын (а)-аас (в)-д заасан нөхцлүүдийн аль нэг нь үүссэн тохиолдолд арваас (10) доошгүй ажлын өдрийн өмнө Зөвлөхөд бичгээр мэдэгдсэний үндсэн дээр энэхүү гэрээг цуцалж болно:

(а) хэрэв Зөвлөх энэхүү гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх явцад гаргасан аливаа алдаа, доголдлыг энэ тухай мэдэгдсэнээс хойш ажлын 7 өдрийн дотор эсвэл түүнээс хойш Үйлчлүүлэгчийн бичгээр зөвшөөрсөн хугацааны дотор залруулаагүй;


(б) хэрэв Зөвлөх нь эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг гүйцэтгэх чадваргүй болсон;

(в) хэрэв Зөвлөх нь (Дэлхийн банкны хүчин төгөлдөр үйлчилж буй Шийтгэлийн журмын дагуу) энэхүү гэрээний сонгон шалгаруулалтад өрсөлдөх болон гэрээг гүйцэтгэхдээ авлига, гэмт

хэрэг, хуйвалдаан, сүрдүүлэг, хоригийн шинжтэй үйл ажиллагаанд оролцсон гэж Үйлчлүүлэгч эсвэл Дэлхийн банк үзсэн;

Үйлчлүүлэгчийг төлөөлж:

З.Баасанням
Авлигатай тэмцэх газрын
Тамгын хэлтсийн дарга,
эрхэлсэн комиссар



Зөвлөхийг төлөөлж:

Крис Алберино
Зөвлөх хувь хүн

A handwritten signature in blue ink, corresponding to the name 'Крис Алберино' (Chris Alberino) listed below it.

Зөвлөхийн гүйцэтгэх ажил

- Монгол Улсад хүрэлцэн ирэхээс өмнө англи хэл дээр бэлэн байгаа тус улсын хууль тогтоомжууд, кейс материалуудтай танилцах;
- Монгол Улсад цахим мэдүүлгийн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэнээс хойш хуримтлуулсан туршлага болон бусад холбогдох улс орны хуримтлуулсан цахим мэдүүлгийн системийн туршлага дээр үндэслэн ХАСХОМ-ын мэдүүлгийн системийг сайжруулж болох хэсгийг тодорхойлох зорилгоор АТГ-ын ХШДШХ болон бусад оролцогч талуудтай хамтран зөвлөлдөх уулзалт зохион байгуулах. Хэлэлцэх асуудлын хүрээ нь хяналт шалгалтын асуудалд чиглэнэ;
- Хяналт шалгалтын ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд ХАСХОМ-ийн системд цахим хяналт, шалгалтын ажиллагаа явуулах боломжийг хэрхэн оруулахыг тодорхойлох зорилгоор а) мэдүүлгийн нэг үечлэл дотор б) мэдүүлгийн хэд хэдэн үечлэл дотор АТГ-ын ХШДШХ-ийн ажилтнуудтай хамтран зөрчлийг илрүүлэх үйл явцыг тодорхойлохын тулд мэдүүлгийн агуулгад дүн шинжилгээ хийнэ. Зөвлөх нь АТГ-ын ХШДШХ-ийн ажилтнуудтай (мэдээллийн технологийн шинжээчдийг оролцуулан) хамтран мэдээллийн санд байж болох төрөл бүрийн зөрчлүүдийг шалгаж, боловсронгуй болгоно. Мөн Зөвлөх нь АТГ-ын ХШДШХ-ийн ажилтнуудтай хамтран мэдүүлгийг сайтар шалгах, тэдгээрт дүн шинжилгээ хийхийн тулд хэрхэн сонгон авах талаар аргачлал боловсруулна (мэдүүлэг дэх мэдээлэл болон гомдол гэх мэт гадаад эх сурвалжийн мэдээлэлд үндэслэж, зөрчлийг илрүүлэх холимог аргачлалыг ашиглах). Мөн зөвлөх нь АТГ-ын ХШДШХ-ийн ажилтнуудтай хамтран гадаад мэдээллийн сан, кейсийн мэдээллийн шийдэл зэрэгтэй харьцуулан шалгах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна. Түүнчлэн Монгол Улс дахь бусад мэдээллийн систем (тухайлбал татварын байгууллагын мэдээллийн систем)-тэй харилцан уялдаатай ажиллах ирээдүйн боломжийг авч үзэж, тэдгээрийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэхтэй холбоотой туршлагыг судлана. Цахим бүрдүүлэлт, хяналт шалгалтын системийн сайжруулах тухай саналд Монгол Улсад ойр бусад тогтолцооны хуримтлуулсан туршлагыг оруулна;
- Дээр дурьдсан зүйлс дээр үндэслэн мэдүүлгийг шалгах цахим бүрэлдэхүүн хэсэг зэрэг асуудлыг оруулсан тайланг АТГ-т боловсруулж өгнө. (зөрчлийг илрүүлэх, шалгах, дүн шинжилгээ хийх зорилгоор мэдүүлгийг сонгон авах аргачлал);
- Зөвлөх нь томилолт дуусгавар болохоос өмнө АТГ-ын ХШДШХ-ийн ажилтнуудад хийсэн ажлынхаа талаар танилцуулга хийнэ;
- Зөвлөх нь тайлан дахь зөвлөмжийн хэрэгжилтийн талаар зааварчилгаа боловсруулж, АТГ-т өгнө. Энэ нь ялангуяа ХАСХОМ-ийн системийн сайжруулалт дээр ажиллах мэдээллийн технологийн компанийн ажлыг хянахад АТГ-т дэмжлэг үзүүлэх болно.

Зөвлөхийн ажлын хуваарь

Зөвлөхийн ажиллах нийт хугацаа дөрвөн долоо хоног байх бөгөөд энэ хугацаанд хоёр удаа Монгол Улсад томилолтоор ажиллана. Зөвлөхийн ажлын эхний долоо хоног нь Монгол Улсад томилолтоор ажиллах бэлтгэл ажлыг хангахад зориулагдана. Ажлын эхний долоо хоног эхлэх үеэр зөвлөх нь и-мэйлээр ХАСХОМ-тэй холбоотой дараах үндсэн хууль тогтоомжийг англи хэл дээр хүлээн авах бөгөөд хэрэв асуух зүйл гарвал зохицуулагчаас нэмэлт мэдээлэл авч болно.

- Авлигын эсрэг хууль;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 5 дугаар тогтоол гэх мэт.

Зөвлөх нь томилолтоос өмнө үндсэн хууль тогтоомжуудтай сайтар танилцсан байвал зохино. Ажлын удирдамжийн II хэсэгт заасан ажил үүргийг гүйцэтгэж дуусгахын тулд зөвлөх нь ХАСХОМ-ийн системийг сайжруулах, хяналт шалгалтын агуулгад дүн шинжилгээ хийх талаар албан тушаалтнуудтай уулзан зөвлөх ажлыг эхний томилолтоороо буюу хоёр долоо хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ. Зөвлөхийг томилолтын хугацаанд нь интернет, ажлын өрөөгөөр хангана. Ажиллах хугацаандаа хийсэн уулзалт, боловсруулсан зөвлөмж дээрээ үндэслэн зөвлөх нь мэдүүлэг дэх зөрчлийг шалгаж тогтоох цахим бүрэлдэхүүн хэсэг болон Монгол Улсын системд тохирсон дүн шинжилгээ, мөрдөн шалгах зорилгоор мэдүүлгийг сонгох аргачлалын тухай оруулсан тайланг бэлтгэж, санал авахаар АТГ-т өгнө. Зөвлөх нь АТГ-ын ХШДШХ-т тайлангийн хүрээнд боловсруулсан дүгнэлт, зөвлөмжийг танилцуулж, АТГ-ын ажилтнуудын саналд үндэслэн тайланг эцэслэнэ.

Хоёр дахь удаагийн томилолтоор зөвлөх нь ХАСХОМ-ийн системийг сайжруулах ажлыг гүйцэтгэж байгаа мэдээллийн технологийн компанийн гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор нэг долоо хоногийн хугацаанд ажиллана. Энэхүү томилолтын хугацаа нь ХАСХОМ-ийн системд хийсэн сайжруулалтын туршилтын үетэй давхацсан байна.